



ХАРХОРИН СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМ-д

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2020.07.28 № 298
танай _____ -ны № _____ -т

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.3, 37.5 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох тус сумын Монгол Ардын намаас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн 2020 оны ээлжит сонгуульд оролцох сумын Монгол Ардын нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцүүлэн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт аймаг дахь Төрийн аудитын байгуулагад ирүүлж, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль 37 дугаар зүйлийн 37.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Аймаг дахь Төрийн аудитын газар нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох сумын Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ “Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020” Тулгуур зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020” Нийцлийн аудитын зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020”, Өвөрхангай аймгийн нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, “Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг”, Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

015030578

D:\Auditiiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Дүгнэлт

Сумын Монгол Ардын намын “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгууль”-д оролцооор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын заалт, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр / хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сумын сонгуулийн хороонд

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЛАМААЧИН



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАРХОРИН СУМЫН
ИТХ-ЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МОНГОЛ АРДЫН НАМЫН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**Хархорин 2020 он
АГУУЛГА**

2

НЭГ. СУМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

- 1.1. Үйлдвэрлэл, үйлчилгээ, хувийн хэвшлийг хөгжүүлэх
- 1.2. Аялал жуулчлал, хот тохижилт
- 1.3. Хөдөө аж ахуй

ХОЁР. ИРГЭДИЙН ХӨГЖИЛ

- 2.1. Эрүүл, мэнд, боловсрол, спортыг хөгжүүлэх
- 2.3. Орлоготой, орон сууцтай өрх
- 2.4. Амар амгалан гэр бүл

ГУРАВ. ШУДАРГА ЁС, ХАРИУЦЛАГА

- 3.1. Шударга ёсыг бэхжүүлэх
- 3.2. Иргэндээ хүрсэн төрийн үйлчилгээ

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ

- 4.1. Газрын доройтлыг бууруулах
- 4.2. Ой, булаг, рашаан хамгаалах



2
3

A handwritten signature in black ink, appearing to read "Г. Нямжавын". To the right of the signature are two small numbers, "2" and "3", stacked vertically.

Өвөрхангай аймгийн Хархорин сумын манын
Хорооны тэргүүлэгчдийн 2020 оны 06 дугаар сарын 22-ны
Өдрийн 05 тоот тогтоолын хавсралт

НЭГ. СУМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

1.1. Үйлдвэрлэл, үйлчилгээ, хувийн хэвшлийг хөгжүүлэх

- 1.1.1. Малын эрдэст тэжээлийн үйлдвэр байгуулж, ойролцоо сумдыг хангана.
- 1.1.2. Сумын мах боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг дэмжиж, экспортод гаргах мах, махан болон дайвар бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлнэ. Малын түүхий эдийн хаягдалгүй үйлдвэрлэл хөгжүүлнэ.
- 1.1.3. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. Орхон багт сүү боловсруулах цех байгуулна.
- 1.1.4. Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, суманд баригдах бүтээнд байгуулалтад материал нийлүүлдэг болгоно.
- 1.1.5. Жижиг, дунд үйлдвэрийн дэвшилтэй шинэ технологи ашиглах, импортыг орлох бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх аж ахуйн нэгжийг тусгай бодлогоор дэмжинэ.
- 1.1.6. Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлнэ.
- 1.1.7. Хархоринд үйлдвэрлэв брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлийг дэмжиж, брэнд бүтээгдэхүүний худалдааны төв байгуулна.
- 1.1.8. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад сумын аж ахуйн нэгж, иргэдийг давуу эрхтэй оролцуулна.
- 1.1.9. Гарааны бизнес эрхлэх хүсэлтэй, эрхэлж буй залууст шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох сургалт, арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлнэ.
- 1.1.10. Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Өвөрхангай аймаг дахь нутгийн зөвлөлийн үйл ажиллагааг сумын хувийн хэвшилтэй холбож ажиллана.
- 1.1.11. Шинээр ажлын байр нэмэгдүүлсэн иргэд, аж ахуйн нэгжийг урамшууллын бодлогоор дэмжинэ.
- 1.1.12. Сумын хэмжээнд ажлын байрны мэдээллийг түгзэх, ажилд зуучлах нэгж ажиллуулна.

1.2. Аялал жуулчлал, хот тохижилт

- 1.2.1. Хархориныг аялал жуулчлалд түшиглэсэн жишиг хот болон хөгжүүлж, гадаад, дотоод хамтын ажиллагааг сайжруулна.
- 1.2.2. Эрдэнэзуу-Хархорум музейг холбосон иж бүрэн тохижилт бүхий аялал жуулчалын гудамж байгуулна.
- 1.2.3. Жуулчны мэдээллийн цогц төв байгуулна. Аялал жуулчлалын байгууллагууд, төрийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулна.
- 1.2.4. Эрдэнэзуу музейд их засвар хийнэ.
- 1.2.5. Торгоны зам, Туурайн төвөргөөн болон аялал жуулчлалын шинэ эвент арга хэмжээ, наадмууд тогтмол зохион байгуулж, жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

- 1.2.6. Жуулчны маршрут дагуу XIII-XVIII зууны түүхэн агуулгатай хөшөө дурсгалын цогцолборууд байгуулна.
- 1.2.7. Жуулчдад худалдаа, үйлчилгээ үзүүлэх павилон, хоолны газрууд, орон нутгийн иргэдийг дэмжиж ажлын байраар хангана.
- 1.2.8. Жуулчдад зориулсан гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй зээл санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.
- 1.2.9. Хархорины нисэх буудлыг олон улсын 4С зэрэглэлтэй болгон хөгжүүлэх Засгийн газрын зорилтыг хэрэгжүүлж ажиллана.
- 1.2.10. Байгалийн үзэсгэлэнт газар, түүх, соёлын дурсгалт газраар аялах дотоодын аялал жуулчлалын маршрут тогтооно.
- 1.2.11. Хархорин-Хужиртын хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлэн Бат-Өлзий чиглэлийн аялал жуулчлалын зам барина.
- 1.2.12. Доод өргөн чөлөөнөөс онгоцны буудал хүртэл авто зам барина.
- 1.2.13. Сумын төвийн өнгө үзэмжид муугаар нөлөөлж байгаа нурж балгас болсон барилгын үлдэгдлийг зайлцуулах, цэвэрлэх ажлын зохион байгуулна.
- 1.2.14. Төв гудамжны самбар, аж ахуйн нэгжийн хаяг, тохижилтыг стандарттай болгож сайжрууна.
- 1.2.15. Цагдаагийн гүүний хойноос 2-р цэцэрлэгийн араар баруун өргөн чөлөө хүртэл хатуу хучилттай зам барина.
- 1.2.16. Баруун өргөн чөлөөнөөс захын араар зүүн өргөн чөлөөг холбосон хатуу хучилттай зам барина.
- 1.2.17. Баруун өргөн чөлөөний засмал замыг урагшаа чигээр нь үргэлжлүүлэн суваг дээгүүр гүүр тавьж, 60 айлын замтай холбосон хатуу хучилттай зам барина.
- 1.2.18. Шанх дэлгүүрийн уулзвараас Санкар хороо хүртэл хатуу хучилттай авто зам барина.
- 1.2.19. Луваанжалба, Хаадын хөшөө чиглэлд хатуу хучилттай авто зам барина.
- 1.2.20. Сумын төвийн дугуйн зам, явган хүний зам, авто зогсоолыг нэмэгдүүлнэ.
- 1.2.21. Сумын төвийн нийтийн тээвэр, автобусны үйлчилгээг сэргээнэ.

1.3. Хөдөө аж ахуй

- 1.3.1. Орчин үеийн мах, сүүний фермерийн аж ахуй хөгжүүлж, сумын иргэдийг хямд үнэтэй мах, сүүн бүтээгдэхүүнээр хангана.
- 1.3.2. Малчид, фермерүүдийг малын эрдэст тэжээлээр хангана.
- 1.3.3. Иргэд, малчдын сүү цагаан идээний борлуулахыг дэмжиж, үзэсгэлэн худалдаанд тогтмол зуучлан оролцуулна. Экспортод гаргах бүтээгдэхүүний судалгааг хийж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
- 1.3.4. Үндэсний сүүний үйлдвэрт сүү бэлтгэн тушаасан малчдад сүүний урамшуулал олгох ажлыг салбарын яамтай хамтран оновчтой зохион байгуулна.
- 1.3.5. Малыг эрүүлжүүлэх, чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, малын тоог чанарт шилжүүлнэ. Шилмэл үүлдрийн хээлтүүлэгч, хээлтэгч нийлүүлэх ажлын бодлогоор дэмжинэ.

- 1.3.6. Малын вакцин, халдварт өвчний тарилга, тарианы хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.3.7. Малын тэжээл тариалж байгаа иргэд, аж ахуйн нэгжийг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжинэ.
- 1.3.8. Нарийн хүр, Онгоцон-Ухаа болон бусад багийн малын тэжээл тариалалт, хангамжийг нэмэгдүүлнэ.
- 1.3.9. Малчдын байгаль цаг уурын эрсдэлийг даван туулах чадавхыг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.3.10. Шанх, Онгоцон-Ухаа багт мал угаалгын механиюксан ванн байгуулж, сумын хэмжээнд малын паразит өвчнийг бууруулна.
- 1.3.11. Малчид, тариаланчдын харилцан ойлголцсон хамтын ажиллагааг бий болгоно.
- 1.3.12. Газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэдэд техникийн тусламж, засвар үйлчилгээ үзүүлэх дундын төв байгуулна.
- 1.3.13. Өрхийн тариаланг хөгжүүлж, техник, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулна.
- 1.3.14. Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж, жимс жимсгэнэ, төмс, хүнсний ногоо тариалалтыг нэмэгдүүлнэ.
- 1.3.15. Хүнсний ногоо даршлах, савлах санаачилгыг хөнгөлөлттэй зээлээр дэмжинэ.
- 1.3.16. Рапс тариалах талбайн хэмжээг хязгаарлана. Олон наст ургамал тариалж хөрсний үржил шимийг дээшлүүлнэ.

ХОЁР. ИРГЭДИЙН ХӨГЖИЛ

2.1. Эрүүл, мэнд, боловсрол, спортыг хөгжүүлэх

- 2.1.1. Иргэн бүрийг эрүүл мэндийн оношилгоонд жил бүр хамруулах зорилтыг хэрэгжүүлж, иргэдийг жилд нэгзээс цөөнгүй удаа үзлэгт хамруулна.
- 2.1.2. Сумын нэгдсэн эмнэлэг, өрхийн эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх чадавхи, оношлогооны тоног төхөөрөмжийг сайжруулна.
- 2.1.3. Элэг бүтэн Монгол, Эрүүл шүд-Эрүүл хүүхэд үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж, өвчлөлийг бууруулна.
- 2.1.4. Эмч, сувилагчдын ажиллах орчинг сайжруулж, эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын сувилагч, асрагчийн хүрэлцээг нэмэгдүүлнэ.
- 2.1.5. Сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмадад зориулсан нөхөн сэргээх төвийн үйл ажиллагааг тогтвортжуулж өргөжүүлнэ.
- 2.1.6. Хүүхдийн сурах сонирхол, авьяас чадварыг нээн хөгжүүлж, сонгон, секц, дугуйлангийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.
- 2.1.7. Багш нарын хөгжлийг дэмжиж, мэргэжил дээшлүүлэх гадаад, дотоодын сургалт, үйл ажиллагаанд хамруулна.
- 2.1.8. Элсэлтийн ерөнхий шалгалт, аймаг, улсын олимпиадад үзүүлсэн багш, сурагчдын амжилтыг урамшуулна.

- 2.1.9. Багийн спортоор Хархорин лигийн тэмцээнийг (гар бөмбөг, сагсан бөмбөг, хөлбөмбөг) өндөр түвшинд зохион байгуулна.
- 2.1.10. Ерөнхий боловсролын Гүнзгий сургуульд футзалны стандартын хөлбөмбөгийн талбай байгуулна.
- 2.1.11. Спортын ордонг түшиглэн аймаг, бүс, улсын хэмжээний спортын тэмцээнийг зохион байгуулна.

2.2. Ажилтай, орлоготой, орон сууцтай өрх

- 2.2.1. Иргэд бизнес хийх, хувиараа хөдөлмөр эрхлэхийг бүх талаар дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.
- 2.2.2. Орлого багатай өрхийн иргэдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 2.2.3. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн зээлийг ажлын байр бий болгоход зарцуулна. Зээлийг олон нийтийн оролцоотой ил тодоор шалгаруулж, ашиглалт, гүйцэтгэлийг хянадаг болно.
- 2.2.4. Хархорин суманд олон төрлийн (орлогод нийцсэн, түрээсийн, ногоон) орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, 250-иас цөөнгүй орон сууц барина.
- 2.2.5. Сумын төвийн хуучин орон сууцнуудыг дахин төлөвлөлтөд оруулна.
- 2.2.6. Төрийн албан хаагчдын орон сууцны асуудлыг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.
- 2.2.7. Сумын ахмадууд, зорилтот бүлэгт чиглэсэн түрээсийн орон сууцны дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.2.8. Хархорин ус суваг орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагааг өргөтгөж, гэр хорооллын 200-гаас цөөнгүй өрхийг цэвэр, бохирын шугамд холбоно.

2.3. Амар амгалан гэр бүл

- 2.3.1. Нийгмийн халамжийн үйлчилгээг сумын зорилтот бүлэгт чиглүүлнэ.
- 2.3.2. Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхэд, гэр бүлд ээлтэй хамгааллын бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.3.3. Угийн бичиг хөтлөх, цус ойртолтоос урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажиллана.
- 2.3.4. Гэр бүл, хүүхэд, оюутан, залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх орчин бий болгоход зориулсан, үзвэр, үйлчилгээ бүхий төвүүд байгуулна.
- 2.3.5. Сумын ахмад настны хөгжлийн төвүүдийн үйл ажиллагааг дэмжиж, шинээр чийрэгжүүлэх тоног төхөөрөмж бүхий Ахмадын өргөө байгуулна.
- 2.3.6. Гудамж, талбай, гэр хорооллын гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, камержуулж, аюулгүй байдлыг хангана.
- 2.3.7. Сумын төвийн шуудууг цэвэрлэж, иргэд, оршин суугчдын амралтын бүс, ногоон бүс байгуулна.
- 2.3.8. Сумын гэр хорооллын ус түгээх худгуудыг цахим картаар 24 цагийн турш үйлчилдэг "ухаалаг худаг" болгоно.

- 2.3.9. Орхон багийн Бэлчирийн рашааны байгалын үзэсгэлэнт газрыг түшиглэн хүүхдийн зуслан байгуулах асуудлыг судалж шийдвэрлэнэ.
- 2.3.10. Төвийн багуудад хүүхдийн тоглоомын талбай нэмж байгуулна.

ГУРАВ. ШУДАРГА ЁС, ХАРИУЦЛАГА

3.1. Шударга ёсыг бэхжүүлэх

- 3.1.1. Хууль бус үйлдэл, ёс зүйн зөрчил, авилга, хээл хахууль, албан тушаалын хэрэгтэй тууштай тэмцэж, төрд итгэх иргэдийн итгэлийг сэргээнэ.
- 3.1.2. Төрийн албыг улс төр, бизнесийн явцуу бүлгийн ашиг сонирхлоос ангид байлгана.
- 3.1.3. Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх, намын харьяаллаар ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлнэ.
- 3.1.4. Нийтийн болон төрийн өмчийн бүх хэлбэрийн үр ашигтай, зохистой ашиглалт, хэрэглээг сайжруулна.
- 3.1.5. Гэмт хэрэг, малын хулгай, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоо ажлыг эрчимжүүлж, иргэд аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.
- 3.1.6. Хүний эрхийг хамгаалах, шударга ёсыг хэвшүүлэх чиглэлээр төр, иргэний нийгэм, хувийн хэвшил, иргэдийн санал, санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг дэмжиж ажиллана.

3.2. Иргэндээс хүрсэн төрийн үйлчилгээ

- 3.2.1. Иргэдээс сумын Засаг дарга, түүний тамгын газар, төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулна.
- 3.2.1. Төрийн албан хаагчдыг чадавхжуулах ажлыг тогтмол зохион байгуулж, төрийн үйлчилгээг сайжруулан, хүнд сурталгүй, хялбар, хүртээмжтэй болгоно.
- 3.2.2. Сумын аж ахуйн нэгж, албан байгууллага, үйлчилгээний төвүүдийн утасгүй интернэт (wifi)-ийн орчинг нэмэгдүүлж, үйлчилгээг цахимаар авах боломж бүрдүүлнэ.
- 3.2.3. Багийн төвүүдийн тохижилтыг сайжруулж, багийн дарга нарыг унаагаар ханган, хөдөөгийн иргэд, малчид төрийн үйлчилгээ авах боломжийг сайжруулна.
- 3.2.4. Иргэд олон нийт, сумын хууль хамгаалах байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, хууль сурталчлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг сайжруулна.
- 3.2.5. Иргэд, олон нийтийн оролцоотой газар олголт, газар зохион байгуулалтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй хэрэгжүүлдэг болно.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ

4.1. Газрын доройтлыг бууруулах

- 4.1.1. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үр дүнтэй хийж, бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлнэ. Онгоцон-Ухаа, Жалбаа болон бусад багийн бэлчээрт худаг гаргана.
- 4.1.2. Газрын доройтлыг бууруулах, хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллана.
- 4.1.3. Бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно, мэрэгч амьтадтай байгаль орчинд халгүй аргаар тэмцэж, шаардлагатай хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- 4.1.4. Сумын төвийн үерийн хамгаалалтын далан, суваг, инженерийн барилга байгууламжийг нэмэгдүүлнэ.
- 4.1.5. Хашаандаа мод ургуулсан айл өрхийг урамшуулах бодлого хэрэгжүүлнэ.
- 4.1.6. Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал, хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг хөгжүүлнэ.

4.2. Ой, булаг, рашаан хамгаалах

- 4.2.1. Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаатай хамтарч байгаль хамгааллын шинэ менежмент хэрэгжүүлнэ. Түүх, соёлын дурсгалыг нутгийн иргэдийн оролцоотой хамгаална.
- 4.2.2. Байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тууштай тэмцэнэ.
- 4.2.3. Орхон голын бохирдолтод тогтмол хяналт тавьж, хариуцлагагүй уул уурхайн эсрэг хатуу тэмцэнэ.
- 4.2.4. Түлшний зах ажиллуулж, Баянтээгийн уурхайд үйлдвэрлэсэн шахмал түлшнээр Хархорин сумын иргэдийг хангаж, агаарын бохирдлыг бууруулна.
- 4.2.5. Сумын төв, дээд, доод өргөн чөлөө, сайр орчмын 200 айлд эко жорлон нэвтрүүлж, хөрс, усны бохирдлоос сэргийлнэ.
- 4.2.6. Хархорин сумын цэвэр усны хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг өргөтгөж, харуул хамгаалалтыг сайжруулна.
- 4.2.7. Мойлтын ам болон бусад газар нутагт ойжуулалтын ажлыг үр дүнтэй зохион байгуулж, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 4.2.8. Мойлтын рашаан, Бэлчирийн рашаан, Дунд булгийн, Шармангийн рашаан бусад булаг шандны эхийг хашиж, усны нөөцийг нэмэгдүүлнэ. Рашаан савлаж сумын төвийн иргэдэд хүргэх ажлыг багийн иргэдийн оролцоотой хэрэгжүүлнэ.
- 4.2.9. Ойн нөхөрлөл, бүлэг байгуулах иргэдийн санал, санаачилгыг дэмжинэ.

ХАРХОРИН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО